



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/29

Шивээговь сум

Ёс зүйн дэд хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар зүйлэн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дэд хорооны дарга:

Д.Баттуул

(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Л.Бадамханд

(1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ууганбаяр

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Б.Баярцэцэг

(Нярав)

Нарийн бичгийн дарга:

М.Гантуяа


(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчилтэй

холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулахыг (Ёс зүйн дэд хороо)-нд даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ОТГОНЖАРГАЛ